**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 11 өдөр　　　　Дугаар А/06　　　　Улаанбаатар хот

Хариуцлагатай эргүүл ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 30 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 108 дугаар захирамж, төвийн даргын 2019 оны А/10 дугаартай тушаалаар баталсан Төвийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бүх нийтээр амрах амралтын өдрүүдээр гэр оронгүй, эмзэг бүлгийн иргэдийн хөлдөлт, осголт, учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хорио цээрийн дэглэмийг мөрдүүлэх, төвийн үйл ажиллагааны хэвийн нөхцлийг хангуулан ажиллах хариуцлагатай эргүүл жижүүрийг томилон ажиллуулсугай.

2.Хариуцлагатай эргүүлийн хуваарь, үйл ажиллагааны чиглэлийг хавсралтаар батлсугай.

3.Үйл ажиллагааны чиглэлийг баримтлан болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж, ажлын тэмдэглэл хөтлөн шуурхай албаны утсанд мэдээлэл өгч ажиллахыг хариуцлагатай эргүүл, ээлжийн жижүүрүүдэд анхааруулсугай.

4.Эргүүл хийсэн ажилтнуудын илүү цагийн хөлсийг журмын дагуу тооцон олгохыг нягтлан бодогч /Б.Энхдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА　　　　Г.ЦЭРЭНДУЛАМ

9063982 1115111235

3183600-2

Нийгмийн хамгааллын тусгай төвийн даргын
2020 оны 02 сарын 11 ны өдрийн
A/06 дугаартай тушаалын хавсралт

9093962 1115111235

| д/д | Сар өдөр | Нэрс | Цагийн хуваарь | Ажиллах цаг | Хийх ажлууд | Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 02.24 | С.Одбаяр | 10.00-16.00 | 6 | - Төвийн үйл ажиллагааг өдөр тутмын хяналтаар хангах<br>-Төвд байрлаж буй иргэдийн - хорио цээрийн дэглэм сахиулах<br>-Иргэдийн болон төвийн орчны ариун цэвэр, халдваргүйтгэлийг хяналт тавин хийлгэх<br>- иргэдтэй хамтран байгууллагын орчны 50 метрт эргүүл хийх<br>- Хариуцлагатай жижүүрийн тэмдэглэл хөтөлж ахлах арга зүйчид танилцуулах, 310005 дугаарт мэдээ өгөх | |
| 2 | 02.24 | Э.Пүрэвсүрэн | 16.00-22.00 | 6 | | |
| 3 | 02.25 | Б.Цогзол | 10.00-16.00 | 6 | | |
| 4 | 02.25 | Л.Даваацэрэн | 16.00-22.00 | 6 | | |
| 5 | 02.26 | Д.Ганзаяа | 10.00-16.00 | 6 | | |
| 6 | 02.26 | А.Гантөмөр | 16.00-22.00 | 6 | | |